

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНД, ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

/2025 оны 2 сарын байдлаар/

№	Үзүүлэлт	<u>БОЭТ</u>	Сумдын эмнэлэг	Өрхийн эмнэлэг	Хувийн эмнэлэг	Цэргийн анги	Нийт дүн
1	Нийт үзлэг	32786	16697	17155	10307		76945
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	5097	4418	6430	1075		17020
3	Идэвхтэй хяналтын үзлэг	5745	1506	1775	410		9436
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	11138	3378	3087	2124		19727
5	Нийт төрөлт	141	22				163
6	Хэвтэн эмчлүүлэгчид	1557	1101	526			3184
7	Нас баралт	15	24	17			56

№	Үзүүлэлт	2024.2	2025.2	Өөрчлөлт
1	Нийт үзлэг	69126	76945	7819
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	16236	17020	784
3	Идэвхтэй хяналтын үзлэг	10267	9436	-831
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	17395	19727	2332
5	Нийт төрөлт	203	163	-40
6	Гэрийн төрөлт	0	0	0
7	Хэвтэн эмчлүүлэгчид	3008	3184	176
8	Нас баралт	47	56	9
9	0-1 насны эндэгдэл	5	3	-2
10	1-5 насны эндэгдэл	0	1	1
11	Хурц халдварт өвчин	202	87	-115

Үзүүлэлт	хэмжих нэгж	2024.2 сар	2025.2 сар	өөрчлөлт
Нялхасын эндэгдэл	1000 амьд төрөлтөд	24.6	18.2	-6.4
Үр хөндөлт	1000 амьд төрөлтөд	453.2	466.7	13.5
Үүнээс охидын	хувь	5.4	6.5	1.1
Хурц халдварт өвчин	10000 хүн амд	26.7	11.3	-15.4
БЗДХ	10000 хүн амд	7.2	12.8	5.6
Үүнээс өсвөр үе	хувь	14	21.2	7.2
Хүүхдийн хяналт /0-1 нас/	хувь	77.6	72.1	-5.5
Хүүхдийн хяналт /1-5 нас/	хувь	39.9	30.3	-9.6

I.ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

- Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нийт 76945 хүнд үзлэг шинжилгээ хийсний 22.1%-д нь урьдчилан сэргийлэх болон идэвхтэй хяналт тандалтын үзлэг хийгдсэн байна.
- Ортой эмнэлгүүдэд нийт 3184 хүнийг 22236 ор хоногоор хэвтүүлэн эмчилсэн нь нэг хүн дунджаар 7.0 хоног хэвтэн эмчлүүлсэн байна.
- Түргэн тусламжийн 1724 дуудлагад явж үйлчилсний 226 (13.1%) нь алсын дуудлага, 100 (5.8%) нь осол гэмтлийн яаралтай дуудлага байсан байна.
- Нийт эмийн сангууд 36082 жор хүлээн авч, 3 тэрбум гаруй төгрөгний эм бараа борлуулалт хийсэн байна.
- ЭЭСангуудад нийт 3161 жор ирсний 30.9% (978) нь ЭМДаатгалын, 0.3% (8) мансууруулах сэтгэц нөлөөт эмийн, 68.8% (2175) нь энгийн эмийн жор байсан байна. Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт дундажаар 52.9% байна.

II.БҮРТГЭГДСЭН ӨВЧЛӨЛ, ЭНДЭГДЭЛ

1. 2 сарын байдлаар 19727 халдварт бус өвчлөл шинээр бүртгэгдэж эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2332 тохиолдлоор өссөн байна. Нийт өвчлөлийн 65.4% нь шинэ өвчлөл байна.
2. **Үүнээс тэргүүлэх 5 өвчлөл нь:**
 1. Амьсгалын тогтолцооны өвчин-6678
 2. Хоол шингээх эрхтний өвчин-2419
 3. Шээс бэлэгсийн тогтолцооны өвчин-1774
 4. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин-1460
 5. Арьс харшил-1260
3. 2 сарын байдлаар 283 хүн осол гэмтэлд өртсөний улмаас тусламж авсан ба өвчлөл өнгөрсөн оноос 18 тохиолдолоор буурсан байна.
4. Оны гарсаар 56 хүн нас барсан ба нийт нас барсан хүний 14,3% нь хорт хавдраар, 7.1 % нь зүрхний шигдээс, тархинд цус харвалт зэрэг сэргийлж болох эндэгдэлээр, 16,1% нь осол гэмтэлээр, 3.6 нь чихрийн шижин өвчнөөр тус тус нас барсан байна. Нийт нас баралтын 18 нь эмнэлэгт, бусад нь гэртээ хээр гадаа нас барсан байна.
5. **Нас баралтын шалтгаан:**
 - 1.Цусны эргэлтийн тогтолцооны өвчин-16
 - 2 Хорт хавдраар-8
 3. Осол гэмтлээр-9
 4. Амьсгалын тогтолцооны өвчин-6
 5. Хоол шингээх эрхтний өвчин-4
 - 6 .Чихрийн шижин-2
 7. Мэдрэлийн тогтолцооны өвчин-2
 - 8.Бөөрний архаг дутагдал-2
 9. Перинаталь үеийн эмгэг-2
 10. Үжил-1
 11. Архины хордлого-2
 - 12.R54- хөгшрөл-1
 13. R96.0-Агшин зуурын үхэл-1

III.ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

- Нийт 163 эх төрж 165 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 38 төрөлтөөр хүн амын төрөлт буурсан байна. Нийт төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа 1,1:1 байгаа ба эрэгтэй хүйс давамгайлж байна.
- Нийт төрөлтийн 9.2 % (15) дутуу төрөлт эзэлж байна.
- Нийт төрөлтийн 3.7% (6) охидын төрөлт эзэлж байгаа ба өнгөрсөн оны мөн үеэс 10/ 4.1-р буурсан үзүүлэлт байна.(ДЗ-1, НО-1,ЦЦ-2,ХБ-1, бусад газар 1).
- 2 сарын байдлаар 77 эх үр хөндүүлж 1000 амьд төрөлтөд 466.7 байгаа нь өнгөрсөн оноос 13.5-р өссөн үзүүлэлт байна.
- 235 жирэмсэн эх хяналтанд шинээр орсны 219 (93.2%) эрт, 16(6.8%) хожуу хяналтад орсон байна.
- Нялхсын эндэгдлийн 3 тохиолдол бүртгэгдсэн байна. Эндэгдлийн шалтгаан нь бактерт мэнэн, нярайн амьсгалын гачаалын шалтгаантай байна.
- 2 сарын байдлаар 5653 хүүхдийг идэвхтэй хянаж, хооллолт өсөлт хөгжилтийн байдлыг үнэлэн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн нь хяналтад хамрагдвал зохих хүүхдийн 37,8% эзэлж байна. Хяналтанд хамрагдсан хүүхдүүдээс 11 хүүхэд жингийн алдагдалтай байгаа нь нийт хүүхдийн 0,2%-г эзэлж байгаа ба 29 хүүхэд туранхай, 15 хүүхэд өсөлт хоцрогдолтой байна.
- 0-1 насны хүүхдийн хяналт 72.1%, 1-5 хүртэлх насны хүүхдийн хяналт 30.3%-тай байна.

IV. ХАЛДВАРТ ӨВЧИН

- Он гараад 186 халдварт өвчин бүртгэж эмчилсэн нь өнгөрсөн оноос 71 тохиолдлоор буурсан байна. Нийт халдварт өвчний 53,2%-г БЗДХ, 36,0%-г салхинцэцэг, 1,1%-г цусан суулга, 2,7%-г гар хөл амны өвчин, 1,6%-г ёлом, 1.1%-г цочмог вируст гепатит, 1,6-г сүрьеэ зэрэг өвчнүүд тус тус эзэлж байна.
- БЗДХ-н 8/8.1%/ нь урьдчилан сэргийлэх үзлэгээр, 85/85.9/% нь өвчний учир амбулатороор, 6/6.1/% нь тандалтын үзлэгээс илэрсэн байна.

АНХААРАЛ ТАТСАН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

1. Төрөлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.
2. 1000 амьд төрөлтөд үр хөндөлт өнгөрсөн оноос 13.5-р өссөн.
3. Нас баралт, ялангуяа сэргийлж болох хавдар, чихрийн шижин, зүрхний шигдээс, осол гэмтэл, архины хордлого зэрэг шалтгаант нас баралт нийт нас баралтын 44.6% эзэлж байна.
4. БЗДХ өнгөрсөн оны мөн үеэс нэмэгдсэн байна.
5. Хүүхдийн хяналтын хувь өнгөрсөн оны мөн үеэс буурсан ба өсөлт хоцролттой, жингийн алдагдалтай, туранхай хүүхдийн тоо нэмэгдсэн байна.

Мэдээлэл бэлтгэсэн: ЭМГ-н статистикч О.Хандармаа , Ш.Нарандалай

2025 оны 3 сарын 5